

Э-Сонин



MONGOLIAN
STOCK EXCHANGE



МОНГОЛЫН ҮНЭТ
ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД
FTSE-MSE ШИНЭ ИНДЕКС
ТООЦООЛОХ ГЭРЭЭНД
ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



"НАКО ТҮЛШ" ХК-ийн ХУВЬ ЭЗЭМШИЛД
ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО, ХОНКОНГИЙН
ҮНЭТ ЦААС, ФЬЮЧЕРСИЙН
ХОРООТОЙ ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ САНАМЖ
БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ
ЗУРЛАА



"ТТСЕК" ХХК-ийн ГИШҮҮНИЙ ЭРХИЙГ
ЦУЦАЛЛАА



МЭДЭГДЭЛ



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН АНХАН ШАТНЫ
МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ 12 САРЫН 2-НД
ЭХЭЛНЭ

Үйл явдал

- Их Британийн "FTSE" групп "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-тай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зуржээ
- "Шарын гол" ХК "Нако түлш" ХК-ийн хувьцааг сайн дурын үндсэн дээр худалдан авах саналын дагуу арилжаа амжилттай хийгдлээ
- Монголын Улсын Санхүүгийн зохицуулах хороо, Хонконгийн үнэт цаас, фьючерсийн хороотой "Хамтын ажиллагааны санамж бичиг"-т гарын үсэг зурлаа
- "ТТСек" ХХК-ийн гишүүний эрхийг цуцаллаа
- Мэдэгдэл

Үнэт цаасны зах зээлийн статистик мэдээлэл

- 10-р сарын арилжааны мэдээ

Сургалт

- Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох сургалт 12-р сарын 2-ны өдөр эхэлнэ.

Мэдээллийн алба
Цахим хуудас: www.mse.mn
Утас: 11-313747

ИХ БРИТАНИЙН “FTSE” ГРУППТЭЙ “МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН БИРЖ” ХАМТРАН АЖИЛЛАХ
ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE групп болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК хамтран “Санхүүгийн индекс боловсруулан тооцоолох чиглэлээр хамтран ажиллах гэрээ”-нд 2013 оны 10 сарын 18-ны өдөр гарын үсэг зурлаа.



FTSE групп нь дэлхийн санхүүгийн төв Лондон хотноо байрладаг бөгөөд 80 гаруй улсын хөрөнгийн зах зээлийн 120,000 гаруй индексийг арилжааны эцэст болон бодит цагийн горимоор тооцоолон гаргаж зах зээлд мэдээлдэг.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргахдаа зөвхөн FTSE-гийн индексийн тооцоолол, зах зээлийн мэдээлэлд суурилдаг нь дэлхийн санхүүгийн зах зээлд асар том байр суурь, нэр хүнд бүхий байгууллага гэдгийг илтгэж буй хэрэг юм.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь FTSE групптэй хамтран Монголын хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтийг олон улсад танигдсан FTSE-

гийн индекс тооцоолох аргачлалын дагуу “FTSE-MSE” шинэ индексийг тооцоолон 2014 оны 2-р улирлаас эхлэн зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Ийнхүү “FTSE-MSE” индексийг нэвтрүүлэх нь зах зээлийн өсөлт бууралтыг бодитой үнэлж тооцоолох, хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчдыг татах, арилжааны идэвх, үнэт цаасны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, улмаар Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааг олон улсын түвшинд нэг алхмаар ойртуулах чухал ач холбогдолтой юм.




SHARYN GOL JSC

Шарын гол (MSE:SHG) ХК-иас Нако Түлш (MSE:NKT) ХК-ийн 92,93% буюу нийт 11,723,989 ширхэг хувьцааг сайн дурын үндсэн дээр худалдан авах саналын дагуу арилжаа амжилттай явагдлаа. Ингэснээр Дархан-Уул аймагт байрлах нүүрс баяжуулах болон шахмал түлшний үйлдвэрийг “Шарын гол” ХК эзэмшиж буй бөгөөд Шарын голын уурхайн нүүрсийг бүрэн шаталттай нүүрс болгон баяжуулах, утаагүй шахмал түлш үйлдвэрлэх зэрэг үйл ажиллагааг 2013 оны 10 дугаар сараас эхлүүлэхээр зорилт тавьж буй ажээ.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, Дархан, Эрдэнэт зэрэг хотуудын гэр хорооллын оршин суугчдын дулааны үндсэн эх үүсвэр болох түүхий нүүрсийг утаагүй түлшээр орлуулж, утаагүй түлшний хэрэгцээг бүрэн

**“НАКО ТҮЛШ” ХК-ИЙН ХУВЬ ЭЗЭМШИЛД
ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО**



хангахаар төлөвлөж байна.

“Шарын гол” ХК-ийн гүйцэтгэх захирал Грам Чапман: “Нако Түлш” ХК-ийг худалдан авах ажиллагаа нь “Шарын гол” ХК-ийн шахмал түлшний энэхүү өндөр боломжит зах зээл рүү нэвтрэн орох үндэс суурьтай хийгдсэн бизнесийн цар хүрээний тэлэлт юм. “Шарын гол” ХК нь утаагүй түлшний бизнесээ улам эрчтэйгээр өргөжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна. Цаашид ч хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор ашиг орлого, мөнгөн урсгалыг өсгөх хамгийн ашигтай хөрөнгө оруулалтуудыг хийж ажиллах болно” гэж онцоллоо.

Эх сурвалж: www.sharyngol.com

ХОНКОНГИЙН ҮНЭТ ЦААС, ФЬЮЧЕРСИЙН ХОРОО САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



2013 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Хонконгийн Үнэт цаас, фьючерсийн хорооны дарга Карлсон Тонг, тус хорооны Бодлогын хэрэгжилтийн газрын захирал Марк Стюарт болон албаны бусад төлөөлөгчид Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороотой мэдээлэл солилцох, харилцан хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурлаа.

Уг санамж бичгийн хүрээнд Хөрөнгийн зах зээлийн шударга, ил тод, нээлттэй, үр ашигтай байх зарчмын дагуу хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаас, төлбөр тооцооны үйл ажиллагааг хянах, мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааны зохистой байдлыг ханган төлөвшүүлэх, түүнчлэн дотоод мэдээлэл ашиглах, зах зээлд манипуляци үүсгэх зэрэг шударга бус гэмт үйлдэлтэй тэмцэх, хууль, эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх зэрэг ажлууд хийхээр төлөвлөсөн байна.

Ажлын айлчлалын хүрээнд Монголын хөрөнгийн биржийн удирдлагууд холбогдох албаны хүмүүстэй, Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагаа, дотоодын зах зээлийн өнөөгийн байдал болон ойрын ирээдүйд хийж хэрэгжүүлэх ажлын талаар хөрөнгийн зах зээлийн хөгжил, цаашдын хамтын ажиллагаа, хууль эрх зүйн орчны чиглэлээр харилцан санал солилцсон юм.

Монголын хөрөнгийн биржид хийсэн уулзалтын үеэр гадны мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг Монголын хөрөнгийн зах зээлд татан оролцуулах, дотоодын зах зээлийг олон улсад сурталчлах чиглэлээр Монголын хөрөнгийн биржтэй хамтран ажиллахаар харилцан тохиролцов.



“ТТСЕК” ХХК-ИЙН ГИШҮҮНИЙ ЭРХИЙГ ЦУЦАЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн 344 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйл, “Гишүүнчлэлийн журам”-ын 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн “ТТСЕК” ХХК-ийн гишүүний эрхийг цуцаллаа.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН АНХАН ШАТНЫ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ 12 САРЫН 2-НД ЭХЭЛНЭ

Хөрөнгийн зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг сар бүр зохион байгуулж байгаа ба сургалт 12 дугаар сарын 2-ны өдөр эхэлнэ.

Монголын хөрөнгийн биржийн байранд санхүүгийн зах зээлд ажиллаж буй мэргэжлийн байгууллагын удирдлагууд, зах зээлд туршлагатай мэргэжилтэн, их дээд сургуулийн багш нар хичээлийг удирдан явуулдаг.

Тус сургалтанд хамрагдахыг хүссэн зах зээл сонирхогч, оролцогч иргэн та бүхэн манай сургалтын төвийн 11 313747-132 утсаар холбогдож дэлгэрэнгүй мэдээллийг авч бүртгүүлж болно.

Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалтанд [энд дарж](#) бүртгүүлнэ үү.



МЭДЭГДЭЛ

Зарим хэвлэл, мэдээллийн хэрэгслээр “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар олон нийтийг төөрөгдүүлсэн үндэслэлгүй, буруу ташаа мэдээлэл гарч буй тул дараах тодруулгыг хийж байна.



Монгол Улсын Их Хурлын 2009 оны 79 тоот, 2010 оны 11 тоот, Засгийн газрын 2010 оны 86 тоот, 2010 оны 115 тоот тогтоолуудын дагуу Төрийн Өмчийн Хороо /ТӨХ/-ноос Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор олон улсын нээлттэй тендерийг зарлаж, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх стратегийн түншээр Лондонгийн хөрөнгийн бирж групп /ЛХБГ/-ийг сонгон шалгаруулсан билээ. Улмаар ТӨХ ЛХБГ-ийн хооронд “Стратеги хамтын ажиллагааны гэрээ”-г 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдөр байгуулж, түншлэлийн хүрээнд хийгдэх ажлуудыг нарийвчлан тусгасан “Ажлын мастер гэрээ”-г 2011 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр ТӨХ, ЛХБГ болон Монголын хөрөнгийн бирж /МХБ/ хамтран байгуулсан.

Энэхүү гэрээний дагуу хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, МХБ-ийн бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, боловсон хүчнийг чадавхижуулахад чиглэсэн олон ажил, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн нь тодорхой, бодит үр дүнд хүрээд байна. Тухайлбал:

- Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль”-ийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн болон шинээр боловсруулж, Монгол Улсын Засгийн газраас дэмжсэний үр дүнд УИХ-аар батлуулахад МХБ голлох үүрэгтэй оролцож ажилласан бөгөөд 2014 оны 01 сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх эдгээр хуулиудад нийцүүлэн хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг зохицуулах 10 гаруй дүрэм, журмуудыг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг хэрэгжүүлж байна.
- “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийг амжилттай хэрэгжүүлэхэд гол чухал угтвар нөхцөл болсон хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн шинэчлэлийн ажлыг амжилттай хэрэгжүүллээ. Тухайлбал, арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж, хяналтын цогц шийдэл бүхий “Милениум Ай Ти” системийг 2012 оны 7-р сарын 2-ны өдрөөс Монголын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлж, олон улсын жишигт нийцүүлсний зэрэгцээ, СЗХ, МХБ, Үнэт цаасны төлбөр, тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв /ҮЦТТТХТ/, брокер дилерийн компаниуд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа билээ.
- Энэхүү системийг нэвтрүүлэхийн зэрэгцээ хөрөнгийн зах зээлийн төлбөр, тооцоог урьдчилсан төлбөрт хэлбэрээс “Т+3” горимд шилжүүлсэн нь гадаадын хөрөнгө оруулалтыг Монголд оруулах ажил идэвхжүүлж, үнэт цаасны кастодианы үйл ажиллагаа нэвтрүүлэх, гадны хөрөнгө оруулалтын сангуудыг Монголын зах зээлд оруулахад шийдвэрлэх ач холбогдолтой болно. Арилжааны төлбөр, тооцоог МонголБанк, арилжааны банкуудаар дамжуулан гүйцэтгүүлэх болж, клиринг банкны үйл ажиллагааг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлсэн нь олон улсын жишигт нийцүүлсэн чухал арга хэмжээ болсон юм.
- Монголын хөрөнгийн зах зээлд ажиллаж буй мэргэжлийн боловсон хүчний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Лондонгийн академи-д 120 гаруй мэргэжилтнийг сургалтанд хамруулж, МХБ-ийн дотоодын сургалтыг сар бүр тогтмол явуулж, сүүлийн жилүүдэд 1000 гаруй мэргэжилтнийг бэлтгэн гаргалаа.
- Хөрөнгийн зах зээлийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулах зорилгоор МХБ цахим хуудсаараа дамжуулан бүртгэлтэй хувьцаат компаниудын санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, шийдвэрүүдийг цаг алдалгүй хүргэж байгаагийн үндсэн дээр, ХК-иудын засаглал сайжирч, тухайлбал өмнөх онд 97 компани санхүүгийн тайлангаа ирүүлсэн бол 2013 онд 217 болж 2.23 дахин өссөн үзүүлэлттэй байна.
- Түүнчлэн, хөрөнгийн зах зээлийн талаар ард иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд шаардлагатай бүхий л мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор МХБ-ээс үнэт цаасны зах зээлийн талаарх сургалтын материал, гарын авлагуудыг боловсруулан гаргаж, өөрийн цахим хуудсаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж байгаа билээ.

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн зарим хэрэгслээр Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааны талаар үндэслэлгүй, буруу ташаа мэдээлэл гарах болж, олон нийтийг төөрөгдүүлж байгаад “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн зүгээс харамсаж байгаа бөгөөд дараах тодруулгыг хийж байна.

1. “Миллениум Ай Ти” системийг Монголын хөрөнгийн зах зээлд 2012 оны 7 дугаар сард нэвтрүүлснээс хойш өдгөө 1 жил гаруйн хугацаанд ямар нэг гэмтэл, саатал гараагүй хэвийн ажиллаж байна. Энэхүү системийг Лондонгийн хөрөнгийн биржийг оролцуулан дэлхийн 20 гаруй орны 30 гаруй хөрөнгийн бирж, санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд арилжааны төлбөр, тооцоог “Т+3” горимоор хэрэгжүүлж, багцын арилжаа, тендер саналын захиалгыг тусдаа сангаар явуулах, маркет мэйкинг хийх, онлайн арилжаа явуулах зэрэг олон шинэ боломжууд нээгдсэн юм. Тухайлбал, 2013 оны 4 дүгээр сараас эхлэн брокер дилерийн компаниуд алсаас буюу өөрсдийн офисоос онлайн арилжаанд оролцож эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 15 брокерийн компаниуд онлайн арилжаа хийж байгаа зэргээр шинэ системийн ашиг тусыг бодитойгоор хүртэж эхэлсэн байна.



“Миллениум Ай Ти” систем нь арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж, хяналтын дэд системүүдээс бүрдэх бөгөөд анхдагч зах зээлийн /IPO/ системийг агуулдаггүй билээ. Энэ нь олон улсад анхдагч зах зээлийн захиалгын хуваарилалт, арилжааг хөрөнгийн бирж бус хөрөнгө оруулалтын банкууд хийдэг практиктай холбоотой юм. Дотоодын зах зээлийн онцлогийг харгалзан анхдагч зах зээлийн арилжааны системийг захиалан нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд компаниуд үнэт цаасаа анхдагч зах зээлд гаргах тохиолдолд арилжааг өмнөх системээр хэвийн явуулах боломжтой хэвээр байгаа болно. Шинээр нэвтрүүлсэн энэхүү системийн ажиллагааг олон улсын стандартад нийцэж буй эсэхийг олон улсад хүлээн

зөвшөөрөгдсөн хөндлөнгийн аудитын байгууллагаар аудит хийлгэхэд бэлэн байгаа тухайгаа МХБ-ээс удаа дараа илэрхийлж байгаа болно.

2. Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төслийн нийт зардлын төсвийг МУ-ын ЗГ-ын шийдвэрийн дагуу 14.2 сая ам.доллар байхаар тогтоосон бөгөөд энэхүү төсөвт МХБ болон ҮЦТТТХТ-ийн техник, технологийг шинэчлэх, боловсон хүчнийг чадавхижуулах, хууль эрх зүйн орчныг шинэчлэх зөвлөгөө, туслалцаагаар хангах зэрэг олон арга хэмжээ, ажил багтсан болно. Улсын төсвөөс энэхүү төсөлд 2011 онд 5.2 сая ам.долларын санхүүжилтыг олгосноос хойш дахин санхүүжилт аваагүй бөгөөд арилжааны банкуудаас 1.7 сая ам.долларын зээл авч, гэрээний хүрээнд нийтдээ 6.9 сая ам.долларын зарцуулалт хийгдсэн болно.

3. МХБ-ийн арилжааны хэмжээ сүүлийн жилд буурсан нь нийт арилжааны 90 орчим хувийг эзэлдэг гадаадын хөрөнгө оруулалт эрс буурсантай холбоотой бөгөөд Монголын эдийн засаг, хөрөнгө оруулалтын байдал сэргэх хүртэл түр зуурын шинжтэй гэж үзэж байна. МХБ-ийн зүгээс гадаадын хөрөнгө оруулагчдад Монголын хөрөнгийн зах зээлийг сурталчлах, үнэт цаас гаргаж, хөрөнгө босгох сонирхол бүхий аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд татан оролцуулах, хөрөнгө оруулагчдын мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, семинар, төрөл бүрийн арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байгааг дурьдах нь зүйтэй.

МХБ-ийн үйл ажиллагааны талаар бодит бус мэдээлэл гаргаж, олон нийтийг төөрөгдүүлж байгаа нь хөрөнгийн зах зээлийг шинэчлэн хөгжүүлэх томоохон зорилт тавин ажиллаж буй манай хамт олны бүтээлч үйл ажиллагааны урам зоригийг мохоож, аливаа мэдээ мэдээлэлд цочмог тус хөрөнгийн зах зээлд оролцох гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг үргээх сөрөг үр дагавартай болохыг онцлон тэмдэглэхийг хүсч байна.

- - -00000- - -

Сарын арилжааны мэдээ

2013 оны 10 дугаар сар

| Арилжааны товч мэдээ | |
|-----------------------------|----------------------|
| Арилжигдсан ширхэг /төг/ | 16,473,156.0 |
| Нийт үнийн дүн | 48,689,698,904.0 |
| Хэлцлийн тоо | 1,516.0 |
| Арилжигдсан үнэт цаасны тоо | 93.0 |
| Зах зээлийн үнэлгээ /төг/ | 1,541,501,618,349.00 |
| ТОП-20 индекс | |
| Хаалт | 15141.45 |
| Өмнөх сарын хаалт | 13816.13 |
| Өөрчлөлт /нэгж | -15141.45 |
| Өөрчлөлт /%/ | 91.24707343 |
| 52 долоо хоног дээд | 18301.93 |
| доод | 13188.46 |



| Идэвхтэй арилжигдсан үнэт | | | | | | | | | |
|---------------------------|--------|-------------------|-----------------|-----------------|----------------|--------|-----------------|-----------------|-----------------|
| Тоо ширхэгээр: | | | | | Үнийн дүнгээр: | | | | |
| № | Симбол | Үнэт цаасны нэр | Арилжсан ширхэг | Үнийн дүн /төг/ | № | Симбол | Үнэт цаасны нэр | Арилжсан ширхэг | Үнийн дүн /төг/ |
| 1 | APU | АПУ | 14748519 | 47662550390 | 1 | APU | АПУ | 14748519 | 47662550390 |
| 2 | HRM | ГЕРМЕС ЦЕНТР | 720675 | 108446253.5 | 2 | TTL | ТАВАН ТОЛГОЙ | 113151 | 376087579 |
| 3 | ETR | Э-ТРАНС ЛОЖ ИСТИК | 291760 | 34719080 | 3 | HRM | ГЕРМЕС ЦЕНТР | 720675 | 108446253.5 |
| 4 | JTB | ЖЕНКО ТУР БЮРО | 165993 | 14108376 | 4 | SUU | СҮҮ | 1041 | 83699740 |
| 5 | HBO | ХАЙ БИ ОЙЛ | 113509 | 41884860 | 5 | BDS | БИДИ СЕК | 19525 | 57600340 |

| Хамгийн их өсөлттэй үнэт ц | | | | | | |
|----------------------------|--------|-----------------|-------------------------|--------------------|------------------|-------------|
| № | Симбол | Үнэт цаасны нэр | Өмнөх сарын хаалт /төг/ | Хаалтын ханш /төг/ | Ханшийн өөрчлөлт | |
| | | | | | төгрөг | хувь |
| 1 | MVO | МОНГОЛ ШЕВРО | 1200 | 1950 | 0 | 62.5 |
| 2 | BUK | УБ БҮК | 25320 | 40000 | 750 | 57.9778831 |
| 3 | MNS | МОННООС | 2100 | 3180 | 14680 | 51.42857143 |
| 4 | TTL | ТАВАН ТОЛГОЙ | 3200 | 4250 | 1080 | 32.8125 |
| 5 | SOI | ЕВРОФЕАЗИА | 1800 | 2380 | 1050 | 32.22222222 |

| Хамгийн их бууралттай үнэт | | | | | | |
|----------------------------|--------|------------------|-------------------|--------------------|------------------|-------------|
| № | Симбол | Үнэт цаасны нэр | Өмнөх сарын хаалт | Хаалтын ханш /төг/ | Ханшийн өөрчлөлт | |
| | | | | | төгрөг | хувь |
| 1 | MNH | МОНГОЛ НЭХМЭЛ | 6500 | 4700 | 0 | -27.6923077 |
| 2 | BHR | БАЯНХАЙРХАН | 680 | 510.42 | -1800 | -24.9382353 |
| 3 | EER | ЭЭРМЭЛ | 2899 | 2300 | -169.58 | -20.6622973 |
| 4 | HNC | БИШРЭЛТ ИНДАСТРИ | 3500 | 2900 | -599 | -17.1428571 |
| 5 | MIB | МОНИНЖБАР | 280 | 235 | -600 | -16.0714286 |